



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 29-ны өдөр

№ 01

Дархан хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлд хувьцаа эзэмшигч М.Цолмон, Л.Амарсанаа, Б.Батром, Ж.Мягмаа, А.Болор-Эрдэнэ, Ж.Мөнхтөр, М.Оюун нар бүртгүүлэн оролцсон ба хувьцаа эзэмшигч М.Оюун өөрийн болон хувьцаа эзэмшигч М.Жавхлангийн хувьцааг итгэмжлэлээр төлөөлөх эрхтэйгээр, хувьцаа эзэмшигч Б.Саруулыг Б.Цэлмэг итгэмжлэлээр төлөөлөх эрхтэйгээр хуралд оролцов.

Компанийн нийт энгийн 265852 ширхэг хувьцаанаас 217324 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, 81,7 хувийн ирцтэйгээр хурал эхлэв.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар хувьцаа эзэмшигч Л.Амарсанааг Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилсныг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100 хувь санал нэгтгэйгээр зөвшөөрөв.

Л.Амарсанаа: Өөр саналтай хувьцаа эзэмшигч байна уу?

Байхгүй байна.

Одоо “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа Л.Амарсанааг хурлын даргаар сонгох саналтай хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Ээлжит хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрөв. Татгалзсан, түдгэлзсэн хувьцаа эзэмшигч байхгүй байв.

Л.Амарсанаа: Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг танилцуулж, батлуулъя.

1.Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх,

2.ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв, ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах,

3.ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,

4.Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгнө. Үүнд: -Ногдол ашгийн тухай,
- Бусад асуудал.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлахыг зөвшөөрч байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрөв.

Л.Амарсанаа Хувьцаа эзэмшигчдийн хурлын дотоод журмыг танилцуулав.

Хурлын дотоод журмыг хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр дэмжиж батлав.

ХЭЛЭЛЦСЭН нь: -Компанийн 2023 оны санхүүгийн тайланг Ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа танилцуулав.

Ж.Мягмаа: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

“Монгол-Алт” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг танилцуулъя. Манай компанийн санхүү тайлант онд түрээсийн орлого, улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэж байгаа ажлын орлогоос бүрдсэн. Энэ онд өмнөх онуудад гүйцэтгэж ирсэн геологи хайгуулын ажлын тайлан дуусна. Геологи хайгуулын ажил дууссан тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тусгах ёстой.

Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй задаргааг уншиж танилцуулав. (Дэлгэрэнгүй тайланг хурлын материалд хавсаргаав).

Л.Амарсанаа:- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн О.Лувсаншарав санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг танилцуулна.

О.Лувсаншарав: - Санхүүгийн тайланг сонслоо. Хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Санхүүгийн тайланд хийсэн хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулав. (Дэлгэрэнгүй дүгнэлтийг хурлын материалд хавсаргаав).

Л.Амарсанаа:- Танилцуулсан асуудлуудтай холбогдуулан асуулт, санал, шүүмжлэл гаргана. Тэгэхээр энэ асуудлаа хэлэлцээд явах, эсвэл цалин, урамшууллынхаа асуудлыг хэлэлцээд дараа нь нэг мөр асуулт, саналаа гаргах уу?

Урамшууллаас асуулт гарч магадгүй учраас энэ хоёртой хамт хэлэлцээд явъя гэсэн саналтай байна.

М.Цолмон:- Тэгье.

Л.Амарсанаа:- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг хэлэлцэж батлах асуудлыг М.Цолмон танилцуулна.

М.Цолмон:- Ерөнхийдөө Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг компанийн ашигт үйл ажиллагааны нөхцөл байдлаас хамаараад урьд онуудад байсан жишгээр нь тогтоолын төсөл оруулж байна.

Л.Амарсанаа:- Асуулттай хувьцаа эзэмшигчид байна уу?

М.Оюун: - Асуулт алга. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ нь татвараа хасаад 40 мянган төгрөг авдаг. Энэ бол үнэхээр бага, олон жил боллоо, анх тогтоосон хувь хэмжээ байгаа юм. Энэ нь одоогийн мөнгөний ханштай харьцуулахад үнэхээр бага шүү.

Санхүүгийн чадавхтай болохоор нэмэх нь зүйтэй.

М.Цэлмэг:- Цалингийн доод хэмжээтэй харьцуулахад бага учир нэмэх нь зүйтэй.

Б.Батром:- Геологийн судалгааны талаар нэг ойлголт өгье гэж бодож байна. Компани маань 2020 оноос геологийн судалгаагаа өргөжүүлье гээд гурван төсөл аваад ажилласан. Хоёр төсөл нь дуусчихсан байгаа. Одоо ашигтай ажиллах боломж байна. Гэхдээ сүүлийн үед геологид хандах хандлага нь өөрчлөгдчихлөө. Сүүлийн үед улсын төсвийн хөрөнгөөр судалгаа хийхээ больсон.

Энэ жил яамнаас агаарын соронзон зураглалын тендер зарласан. Энэ бол агаараас соронзон зураглал хийдэг технологи юм. Салбарын сайд бол геологийн зураглалын ажлыг зогсооё гэсэн. Тэр хүнд тийм ойлголт өгсөн байна.

Цаашдаа энэ тал дээр анхаарна биз. Ямар ч байсан хоёр төслөө хамгаалаад “Монгол Алт” ХК өргүй болсон.

М.Цолмон:- Үнэгт уул төслөөр юу олсон гэлээ?

Б.Батром:- Тос, хий гаргаж авдаг шатдаг занар гэж бүтээгдэхүүний хоёр бассейн олсон.

Л.Амарсанаа:- Ж.Мягмаагаас нэг зүйл асууя? Бид өмнөх жил 1,5 сая доллар зээлж аваад барилгад оруулсан. Энэ “Монгол Алт” ХК-ийн орлого талд бүрэн туссан уу?

Ж.Мягмаа:- Бүрэн туссан.

Л.Амарсанаа:- Барилгын ажилд хэдэн хувь нь орсон бэ?

Ж.Мягмаа:- 4,3 тэрбум нь орсон.

Л.Амарсанаа:- Одоо цаана нь хэдэн төгрөг үлдэж байна?

Ж.Мягмаа:- Зарцуулагдаад дууссан. Одоо борлуулалтын орлого орж ирнэ.

Л.Амарсанаа:- Барилгаа бүрэн дуусахад хэдий хэмжээний зардал гарах тооцоо байна?

Ж.Мягмаа:- Материалын зардалд 273 сая төгрөгийн зардал гарна гэж тооцсон.

Л.Амарсанаа:- Дуусах юм уу? Наадах чинь бага л тоо байна даа. Магадлашгүй ажлын зардал гэж ярвигтай зардал байдаг.

Материалуудаа бүрэн татсан байгаа нь сайн хэрэг. Гэтэл цаана нь мөнгөн дүнгээрээ гарах ажлууд байдаг. Сайн бичиж тэмдэглэж ав. Магадлашгүй ажлын зардал төсөвт өртөгт тусгагдсан байдаг. Үүнийг сайн тооцож байгаад надад танилцуулаарай.

Ж.Мягмаа:- За.

Л.Амарсанаа:- Зээлүүдийг өөр зориулалтаар зарцуулахгүй. Зөвхөн орон сууцны барилгад зарцуулна гэж тохирсон. Зээлийг үр ашигтай байх тал дээр анхаараарай.

2023 оны орлого, зарлагын дэлгэрэнгүй задаргааг гаргаад надад танилцуулаарай. Компанийн цаашдын зорилгоо тодорхойлохдоо юун дээр анхаарах ёстойг мэдэх зорилгоор авч байгаа юм.

Өөр асуулттай хүн байна уу? Байхгүй бол хэлэлцэж байгаа гурван асуудлаар асуултаа дуусгая.

Саналтай хувьцаа эзэмшигч байна уу? Байхгүй байна.

“Монгол алт” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг батлахыг дэмжиж байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөн үү.

Бүгд дэмжив.

“Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2024 оны зардлын төсөв, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын хавсралтад заасан хэмжээгээр батлахыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Бүгд дэмжиж гараа өргөв.

Дараагийн асуудлаа хэлэлцье. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд шинээр нэр дэвших хүмүүсээ танилцуулна. Түүний өмнө тооллогын комисс ажилдаа орох ёстой.

Тооллогын комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллуулна. Тооллогын комиссын даргаар маркетингийн ажилтан Г.Сарнай, гишүүнээр хүний нөөцийн ажилтан Х.Одгэрэл нар томилогдлоо.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүн болон хараат бус гишүүнээр нэр дэвшсэн хүмүүсийг М.Цолмон танилцуулна.

М.Цолмон:- “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр улираан сонгохоор тогтсон. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Амарсанаа, М.Цолмон, М.Оюун, Ж.Мөнхтөр, А.Молор-Эрдэнэ, Б.Цэлмэг нар, хараат бус гишүүнээр О.Лувсаншарав, С.Дорждэрэм, Б.Базарсад нарын нэрийг дахин дэвшүүлж байна .

Л.Амарсанаа:- “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Амарсанаа, М.Цолмон, М.Оюун, Ж.Мөнхтөр, А.Молор-Эрдэнэ, Б.Цэлмэг нарыг, хараат бус гишүүнээр О.Лувсаншарав, С.Дорждэрэм, Б.Базарсад нарыг сонгох саналыг дэмжиж байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Татгалзсан, түдгэлсэн хувьцаа эзэмшигч байхгүй байна. Хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө.

Тооллогын комисс ажилдаа орно уу.

Тооллогын комисс санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулав.

Л.Амарсанаа:- Тооллогын комисс санал хураалтыг дүнг гаргаж дууслаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Монгол алт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоох нь “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Амарсанаа, М.Цолмон, М.Оюун, Ж.Мөнхтөр, А.Молор-Эрдэнэ, Б.Цэлмэг нар, хараат бус гишүүнээр О.Лувсаншарав, С.Дорждэрэм, Б.Базарсад.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сард багтаан хуралдуулж ТУЗ-ийн дарга, түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

2. ТУЗ-ийн анхны хурлаа зохион байгуулж, ТУЗ-ийн дарга сонгох, компанийн засаглалын журам, баримт бичгүүдийг хэлэлцэх, цаашид хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (С.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" "Монгол алт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот тогтоол, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигч байна уу? Асуулт байхгүй байна.

Санал байна уу? Байхгүй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгосон тогтоолын төслийг батлахыг дэмжиж байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү?

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжлээ.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай явагдаж дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа.

Цаашид бүгдээрээ компанийнхаа үйл ажиллагааг сайжруулахын төлөө хамтран зүтгэх болно.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
С.Бат-Эрдэнэ

ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА Л.АМАРСАНАА

